



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20~~10~~ он~~02~~ дугаар  
сарын ~~05~~ ны өдөр

Дугаар ~~XЭР/~~  
~~325~~

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Х.НЯМБААТАР ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Хог хаягдал боловсруулан эрчим хүч үйлдвэрлэх төслийдийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Л.ӨЮҮН-ЭРДЭНЭ

2051070

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Х.НЯМБААТАРААС МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ**

**Асуулга 1. Хог хаягдлыг үнэгүй, татаасгүй нийлүүлэх асуудлыг яаралтай  
шийдвэрлэх боломжтой эсэх**

Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т "энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх" гэж, мөн зүйлийн 9.1.4-т "энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах" гэж тус тус заасан бүрэн эрхийг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлдэг байх тул асуулгад дурьдсан асуудлаар Засгийн газраас хариулт өгөх хууль зүйн боломжгүй байна.

**Асуулга 2. Эрчим хүчний станцын холбогдох зөвшөөрөл, гэрээнүүдийг  
яаравчлах боломжтой эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлнэ үү.**

"Нааново Грин Энержи Монголиа" ХХК нь Улаанбаатар хотын баруун хэсэгт буюу Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт Морингийн давааны хогийн цэгийг түшиглэн 14 мвт-ын хүчин чадалтай цахилгаан станц барих тесэл хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хурлаар хэлэлцэж дэмжсэн.

Мөн тус компаниас эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 20/01/02 дугаартай албан бичгээр гаргаад байна.

Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу хог хаягдлын үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл батлагдаж газрын асуудал шийдвэрлэсний дараа байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийж баталгаажуулан үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгодог.

"Нааново Грин Энержи Монголиа" ХХК-нд хог хаягдаас 14 мвт-ын хүчин чадалтай эрчим хүч үйлдвэрлэх станцыг компанийн өөрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхийг бодлогын хувьд дэмжиж байгаа болно.

-----оо-----